



САНХҮҮГИЙН АУДИТ ТАЙЛАН

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2024 он

Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газрын дарга ,
тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор: Л.Оюунбилэг

Утас: 99519341 Цахим хаяг:

Миндүг аудит .ХХК-ийн захирал: С.Энхтөр

Утас: 95957791 Цахим хаяг: director@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	100

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМГИЙН
ТҮВШИНШИРЭЭ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.ЦЭЦЭГДЭЛГЭР ТАНАА

2024.02.25 № 135
танай _____ - ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн бага дунд боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

2023 онд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 70.7 сая төгрөг, төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,721.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1,452.3 сая төгрөг буюу 84.3 хувийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 183.0 сая төгрөгийг тайланд толилуулсан байна.

D:/Bichig hereg/2024/A4 toot

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн.

Тус сургууль 1-5 ангийн сурагчдын үдийн хоолны батлагдсан нормативд зардал, хүүхэд өдрөөр гаргасан гүйцэтгэлийн зөрүүгээс үүссэн төсвийн хэмнэлтээс 1.0 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлж, 13.5 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлэлгүй үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургууль гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 3 зорилтын хүрээнд 44 арга хэмжээ төлөвлөж 87.9 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	140,848,907.84	272,469,160.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	70,683,464.06	198,809,476.82
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	70,683,464.06	198,809,476.82
3121	Төгрөг	70,683,464.06	198,809,476.82
31211	Төрийн сангийн харилцах	70,683,464.06	198,809,476.82
35	БАРАА МАТЕРИАЛ	70,165,443.78	198,809,476.82
35100	Түүхий эд материал		46,500.00
35130	Эм боох материал		46,500.00
354	Хангамжийн материал	47,350,503.12	54,176,065.94
35410	Бичиг хэргийн материал	1,942,500.00	1,553,500.00
34420	Аж ахуй материал	43,930,903.12	48,378,265.94
35460	Хүнсний материал	806,000.00	980,000.00
35470	Бусад хангамжийн материал	671,100.00	3,264,300.00
35500	Биологийн хөрөнгө	12,534,940.66	15,877,177.96
35600	Мал, амьтад	10,280,000.00	3,560,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,463,529,255.09	1,468,339,700.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,463,529,255.09	1,468,339,700.86
392	Биет хөрөнгө	1,428,267,255.09	1,433,377,700.86
39201	Барилга ,байгууламж , орон сууц	1,512,579,525.00	1,512,579,525.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(253,864,858.16)	(349,536,128.36)
39203	Авто- тээврийн хэрэгсэл	14,560,000.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,560,000.00)	
39205	Машин тоног төхөөрөмж компьютер	260,614,983.37	376,450,477.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	(159,239,287.76)	(164,305,812.98)
39207	Тавилга , аж ахуй эд хогшил	99,610,665.02	92,698,106.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,651,610.00)	(62,201,573.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,209,000.00	9,209,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,796,666.86)	(7,390,000.00)
39217	Ном	42,805,504.48	25,874,106.18
393	Биет бус хөрөнгө	35,262,000.00	34,962,000.00
39301	Программ хангамж	2000,000.00	2000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(850,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	33,812,000.00	33,812,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,604,378,162.93	1,740,808,861.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,004,940.00	500,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,004,940.00	500,000.00
413	Өглөг	1,004,940.00	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,004,940.00	
413205	Тээвэр шатахууны өглөг	332,390.00	
413208	Хоолны өглөг	672,550.00	
41360	Бусад өглөг		500,000.00
41361	Байгууллагад төлөг өглөг		500,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,603,373,222.93	1,740,308,861.58
51	Засгийн газрын оролцоо хувь	1,603,373,222.93	1,740,308,861.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан / орон нутгийн сан	1,119,717,908.98	1,119,717,908.95
51101	Өмч- төрийн	1,119,717,908.98	1,119,717,908.98
512	Хуримтлагдсан үр дүн	114,912,417.05	251,848,055.70
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,488,460,805.88)	114,912,417.05
51220	Тайлант үеийн үр дүн	1,603,373,222.93	136,935,638.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	368,742,896.90	368,742,896.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,604,378,162.93	1,740,808,861.58

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,054,038,230.68	1,932,577,458.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,633,482,030.68	117,811,958.80
1200	Нийтлэг татварын бус орлого	1,633,482,030.68	117,811,958.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,557,100.00	5,284,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,057,100.00	1,784,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	5,300,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	1,533,300,223.90	108,385,681.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Материал	90,624,706.78	3,342,177.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,420,556,200.00	1,814,765,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,289,369,500.00	1,721,765,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,289,369,500.00	1,721,765,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	131,186,700.00	93,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага	131,186,700.00	93,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,420,556,200.00	1,814,765,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,289,369,500.00	1,721,765,500.00
210	БАРАА ,ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,370,446,622.23	1,680,150,391.09
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	917,519,062.94	1,144,355,607.24
210101	Үндсэн цалин	642,974,177.02	768,783,901.74
210102	Нэмэгдэл	200,986,567.02	315,581,379.82
210104	Урамшуулал	73,558,318.90	59,990,325.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,988,900.00	160,096,300.00
210201	Тэтгэврийн даатгал	82,229,300.00	108,865,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,678,900.00	12,807,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,743,400.00	10,246,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,979,100.00	2,561,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,358,200.00	25,615,600.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	74,997,021.73	88,711,437.48
210301	Гэрэл , цахилгаан	21,408,693.48	20,997,757.48
210302	Түлш, халаалт	43,350,828.25	64,008,680.00
210303	Цэвэр, бохир ус	10,237,500.00	3,705,000.00
2105	Норматив зардал	60,003,000.00	84,881,550.00
210502	Хоол , хүнс	60,003,000.00	84,811,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	2,192,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	2,192,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр, хураамж	13,177,602.00	12,020,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,057,100.00	1,784,100.00
210806	Мэдээлэл ,технологийн үйлчилгээ	8,120,502.00	10,236,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	178,761,035.56	187,893,396.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,587,495.75	43,454,907.18
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	14,278,190.00	10,480,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	115,895,349.81	133,957,789.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,218,385.52	93,629,182.52
2132	Бусад ургал шилжүүлэг	80,136,000.00	93,623,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	80,136,000.00	80,316,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		13,306,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	82,385.52	6,082.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,385.52	6,082.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,603,373,222.93	158,797,885.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		21,862,246.54
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		21,862,246.54
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,603,373,222.93	136,935,638.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,430,113,300.00	1,820,849,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,557,100.00	6,084,100.00
1200	Нийтлэг татварын бус орлого	9,557,100.00	6,084,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,557,100.00	5,284,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	9,057,100.00	1,784,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	500,000.00	3,500,000.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр)-ТӨҮГ		800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,420,556,200.00	1,814,765,500.00
1310	Улсын төсвөөс	1,289,369,500.00	1,721,765,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,289,369,500.00	1,721,765,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	131,186,700.00	93,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага	131,186,700	93,000,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,313,305,454.94	1,640,478,787.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,313,305,454.94	1,640,478,787.24
210	БАРАА ,ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,232,746,069.42	1,544,256,404.72
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	917,519,062.94	1,144,355,607.24
210101	Үндсэн цалин	640,741,407.02	768,783,900.74
210102	Нэмэгдэл	200,986,567.02	315,581,379.82
210104	Урамшуулал	75,791,088.90	59,990,325.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,988,900.00	160,096,300.00
210201	Тэтгэврийн даатгал	82,229,300.00	108,865,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,678,900.00	12,807,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,743,400.00	10,246,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,979,100.00	2,561,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,358,200.00	25,615,600.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	74,147,214.48	88,993,917.48
210301	Гэрэл , цахилгаан	21,408,693.48	20,997,757.48
210302	Түлш, халаалт	42,501,021.00	64,291,160.00
210303	Цэвэр, бохир ус	10,237,500.00	3,705,000.00
2105	Норматив зардал	59,589,300.00	85,728,100.00
210502	Хоол , хүнс	59,589,300.00	85,728,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр, хураамж	13,177,602.00	12,020,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,057,100.00	1,784,100.00
210806	Мэдээлэл , технологийн үйлчилгээ	8,120,502.00	10,236,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,323,900.00	49,062,380.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	14,432,190.00	11,102,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,559,385.52	96,222,382.52
2132	Бусад ургал шилжүүлэг	80,477,000.00	96,216,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	80,477,000.00	82,909,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		13,306,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	82,385.52	6,082.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,385.52	6,082.52
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгө гүйлгээ	116,807,845.06	180,370,812.76
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	46,124,381.00	52,244,800.00
22	Хөрөнгийн зардал	46,124,381.00	52,244,800.00
225	Үйл ажиллагааны бус зардал	46,124,381.00	52,244,800.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	46,124,381.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,124,381.00	52,244,800.00
6	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(46,124,381.00)	(52,244,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	70,683,464.06	128,126,012.76
14	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		70,683,464.06
15	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	70,683,464.06	198,809,476.82

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12 –р сарын 31-нээрх үлдэгдэл	1,119,717,908.98	368,742,896.90	64,970,794.74	1,553,431,600.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,553,431,600.02)	(1,553,431,600.62)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,119,717,908.98	368,742,896.90	(1,488,460,805.88)	
9	Тайлант үеийн үр дүн			1,603,373,222.93	1,603,373,222.93
11	2023 оны 12-р сарын 1-ээрх үлдэгдэл	1,119,717,908.98	368,742,896.90	114,912,417.05	1,603,373,222.93
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,119,717,908.98	368,742,896.90	114,912,417.05	1,603,373,222.93
19	Тайлант үеийн үр дүн			136,935,638.65	136,935,638.65
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,119,717,908.98	368,742,896.90	251,848,055.70	1,740,308,861.58

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Мөнгө , түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,873,632,900.00	1,677,626,705.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,873,632,900.00	1,677,626,705.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,777,221,900.00	1,594,717,105.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл	1,326,266,900.00	1,144,355,607.24
210101	Үндсэн цалин	884,177,300.00	768,783,900.74
210102	Нэмэгдэл	373,069,100.00	315,581,380.82
210104	урамшуулал	69,020,500.00	59,990,325.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,096,300.00	160,096,300.00
210201	Тэтгэврийн даатгал	108,865,000.00	108,865,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,807,500.00	12,807,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,246,400.00	10,246,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,561,800.00	2,561,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,615,600.00	25,615,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,000,000.00	88,993,917.48
210301	Гэрэл цахилгаан	24,000,000.00	20,997,757.48
210302	Түлш халаалт	50,000,000.00	64,291,160.00
210303	Цэвэр бохир ус	15,000,000.00	3,705,000.00
2105	Нормативт зардал	85,728,100.00	85,728,100.00
210502	Хоол хүнс	85,728,100.00	85,728,100.00
2106	Эд хогшил урсгал засварын зардал	4,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,236,000.00	10,236,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	10,236,000.00	10,236,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,894,600.00	101,307,181.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,540,700.00	85,953,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,353,900.00	15,353,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,411,000.00	82,909,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,411,000.00	82,909,600.00
213205	Төрөө иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	96,411,000.00	82,909,600.00
1320	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,873,632,900.00	1,820,849,600.00
122005	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	93,000,000.00	93,000,000.00
122005	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,721,765,500.00	1,721,765,500.00
	Өөрийн үйл ажиллагаанаас	6,083,100.00	6,083,100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31.8 сая төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс 8.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 23.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 31.8 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5.2 сая төгрөгөөр их байх боловч 23.7 сая төгрөгийн зөрчил нь материаллаг бус гэж үзсэн тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Тус сургуулийн 1-5 дугаар ангийн суралцагчдын үдийн хоолны батлагдсан нормативд зардал, хүүхэд тус бүрээр гарсан гүйцэтгэлийн зөрүүгээс үүссэн төсвийн хэмнэлтээс 1.0 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлж, 8.1 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээгүй үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*”, Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 “*Энэ хуулийн 38.1.2, 38.1.3-т заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжин зарцуулж болно*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 “*нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх*” гэсэн заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

3.2 Зөвлөмж

Тайлант онд дотуур байрны сурагчдын болон үдийн цай хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан хүнсний бараа бүтээгдэхүүн, суралцагчдын хичээлийн хэрэглэгдэхүүн болон бичиг хэргийн материалд нийт 179.5 сая төгрөгийн зардал гаргасан боловч худалдан авах ажиллагааны журам зөрчиж шууд худалдан авалт хийсэн ба 23.7 сая төгрөгийн хүнсний материал авахдаа харилцагч байгууллага, иргэнтэй гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4. “*хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох*”, 41.2 дахь хэсгийн 41.2.3 “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралтын 2-т “*Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 70.0 сая, шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая*” гэсэн заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, ангилал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх акт, зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан/, тэмдэглээгүй орхисон/.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн	
Үдийн хоолны төсвийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй	1	8,126.9	1	8,126.9									
Гэрээ байгуулаагүй худалдан авалт хийсэн	1	23,690.7					1	23,690.7					
Дүн	2	31,817.6	1	8,126.9	1			23,690.7					